**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 27 өдөр Дугаар А/363 Мандалговь

## Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-нээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 2 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар батлсугай.

2. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 1092 дахь хэсэг, 2007 оны 115 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

Засаг даргын 2021 оны 09 дугаар сарын 07-ны
өдрийн А/363 дугаар захирамжийн хавсралт

| № | Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн | | | | Газар өмчлөх эрх шилжүүлсэн | | Газрын байршил | Газрын хэмжээ /м2/ | Газрын үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Овог нэр | Регистр | | | |
| 1 | Мэнгэт | Чойсамбуу | Эрдэнэцэцэг | ЗЮ65062163 | Б.Тунгалаг | ЗФ90120901 | Нарлаг 5-528 | 598 | 1794000 |
| | | | | | Б.Буянжаргал | ЗЮ92032334 | | | |
| 2 | Боржигон | Болдбаатар | Балжинням | ЗК98112111 | Б.Болдбаатар | ЗЮ77021616 | Айраг 6-670 | 815 | 1630000 |
| | | | | | Ө.Жавзмаа | ЗК73121300 | | | |
| | | | | | Б.Дашням | ЗК03251811 | | | |
| | | | | | Л.Сүглэгмаа | ЗЮ95051200 | | | |